

**МОНГОЛ ОРНЫ ХИЛ
ОРЧМЫН НУТАГ
ДЭВСГЭРИЙН БАЙГАЛ-
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН
ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ
БАЙДЛЫГ ТАНДАХ
СУДАЛГАА”– НЫ АЖЛЫН
ГОЛ АГУУЛГА**

Б.Энх-Амгалан
ШУА-ийн Газарзүй, геоэкологийн
хүрээлэнгийн Нийгэм, эдийн
засгийн газарзүйн салбарын
эрхлэгч, доктор

“Монгол орны хил орчмын нутаг дэвсгэрийн Байгал-нийгэм эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг тандах судалгаа”–ны ажлын гол агуулга, ач холбогдол нь Монгол орны байгаль орчны тэгш бус байдлыг /хил орчмын газар нутаг, тэр тусмаа Баян-Өлгий аймгийн хилийн Алтай, Цэнгэл, Ногооннуур, Цагааннуур сумдын жишээн дээр/ тодорхойлох, зарим шалгуур үзүүлэлтийг хүн амын суурьшил, нутагшилтын хүчин зүйлтэй холбон судалсан гэж ойлгож болно. Монгол орны байгаль орчны тэгш бус байдлыг тодорхойлох үүднээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгон авсан. Үүнд:

1. Уур амьсгалын нутаг дэвсгэрийн ялгавар ба тэгш бус байдал,
2. Эрчим хүчний хангамж, тэгш бус байдал,
3. Уул уурхайн баялаг ба тэгш бус байдал
4. Хүн амын байршил нутагшилт, шилжилт хөдөлгөөн ба тэгш бус байдал зэрэг болно.

Судалгааны үр дүнд байгаль орчны тэгш бус байдал, түүний нөлөөгөөр Монгол Улсын хүн амын суурьшил нутагшилтад бодит сөрөг үр дагавар илэрч байна гэж дүгнэсэн. Тухайлбал: “Их нүүдэл”-ийн нөлөөгөөр сумдын 54 хувь нь 3000 хүрэхгүй хүн амтай болж, сумын төв эзгүйрэх, Улаанбаатар гэсэн суурьшлын ганц төвтэй тогтолцоо үүсэж, улсын нийт хүн амын 46 хувь нь хотод амьдарч, хотжилт 67,6 хувьд хүрсэн байх жишээтэй.

Суурьшлын нэг төвтэй тогтолцоо, “Хэт төвлөрөл” нь орчны бохирдол, ажилгүйдэл, ядуурал, дэд бүтцийн дарамт, хүрэлцээгүй байдал, эрүүл мэнд, боловсрол болон бусад төрийн үйлчилгээний хомсдол зэрэг нийгэм-эдийн засгийн олон сөрөг үр дагавар авчирч байгааг, өөрөөр хэлбэл, өнөөдрийн бидний өдөр тутамд учирч байгаа түгжрэл, утаа, халтиргаа гулгаа, автобус унааны хүрэлцээ, тог цахилгаан, ус ундааны тасалдал гээд энэ бүгдийн үндэс болж байгаа юм.

Хүрээлэн буй орчны тэгш бус байдлын элемент /байгаль-уур амьсгалын нөхцөл, газрын хэвлийн болон гадаргын баялаг, эрчим хүчний хангамж, газрын доройтол г.м/ тус бүрийг байгалийн болон эдийн засгийн бүсээр хүн амын нутагшилтай харьцуулан судалж, амьдрах таатай нөхцөлийн үнэлгээ боловсруулах, улмаар хүн амын нутагшилт суурьшлын тэгш бус байдлыг тэнцвэржүүлэх тулгуур бодлого боловсруулах ач холбогдолтой.

Хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч, алба хааж буй хилийн анги, салбарын, хилчдийн хувьд ч дээрх тэгш бус байдлын нөлөө нэгэн адил хамааралтай байгаа юм.

“Монгол орны хил орчмын нутаг дэвсгэрийн Байгал-нийгэм эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг тандах судалгаа”-ны хүрээнд хилийн бүс нутагт амьдарч буй малчдын бэлчээр, газар ашиглалт, хил хамгаалалд оролцох оролцоо, эдийн засгийн чадамж, хүн амзүйн бүтэц, түүх угсаатан зүй, байгаль-экологийн төлөв, өөрчлөлт, хилийн бүс нутагт тулгамдаж буй асуудал, хилчдийн амьжиргаа, хүндрэл бэрхшээл зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлав. Түүнчлэн хил дээр үүргээ гүйцэтгэж буй хилчдийн нийгмийн хамгаалал, амьжиргаа, сэтгэл ханамж, отряд, заставын боловсон хүчний хангамж болон тулгамдаж байгаа асуудлыг анкет асуулга болон ярилцлагын аргаар судлахын зэрэгцээ хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийн оролцоо, хамтын ажиллагаа зэрэгт дүн шинжилгээ хийхэд оршиж байв.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

❖ Хилийн бүс нутгийн түүхэн газарзүйн судалгаа /газар усны нэрийн өөрчлөлт/

❖ Хилчдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, боловсон хүчний хүртээмж, тулгамдаж буй асуудлыг анкет, ярилцлагын аргаар судлах

❖ Хил хамгаалалтад туслах хүчний оролцоог тодорхойлох зэрэг болно.

Манай орны хилийн бүсэд 14 аймгийн 77 сумын 150 орчим баг хамрагдах бөгөөд өнөөдрийг хүртэл тухайн сум, багуудад нийгэм эдийн засаг, түүх угсаатан, газар бэлчээр, байгалийн баялаг ашиглалт, шилжилт хөдөлгөөн, хөдөөгийн малчид, хил хамгаалагч нарын амьжиргаа, нийгмийн хангамжийн талаар явуулсан цэгцтэй судалгаа үндсэндээ байхгүй гэж үзэж болно.

“Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Монгол улсын хилийн тухай хууль” зэрэг хил хамгааллын үндсэн баримт бичгүүдэд Монгол Улсын “үндэсний аюулгүй байдал”, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, “*нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал*”-ын талаар тусгасан байна. Тухайлбал:

❖ Монгол Улсын “үндэсний аюулгүй байдал” гэж Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ;

❖ Хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар *нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах*, хилийн бүсийн иргэдийн *экологийн тэнцвэрт байдлыг ханган* аюулгүй орчинд амьдрах;

❖ Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн *уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах*;

❖ Хил орчмын нутаг дэвсгэрийн стратегийн ач холбогдол бүхий *байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах*;

❖ Хил орчмын оршин суугчдаас хил хамгаалалтад оролцох явдлыг хөхүүлэн дэмжих, урамшуулах, улсын хилийн бүс, зурваст тогтвортой суурьших нөхцөлийг бүрдүүлэх; гэж заасан явдал нь хил орчмын нутаг дэвсгэрт энэхүү судалгааг явуулах үндэслэл нэгэнт бий болсон гэж үзэж байна. Аливаа улс орон өөрийн хил орчмын нутаг дэвсгэрийг шинжлэх ухаанчаар судлан баримтжуулж, мэдээ датаг архивлан авч үлдэх нь цаашид нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, залгамж халааг хойч үедээ өвлүүлэн үлдээх таатай нөхцөл юм.

Түүнчлэн орчин үед дэлхийн улс орнуудад “Хил судлал”-ын шинжлэх ухаан нь газарзүй, түүх, улс төр судлал, социологи, олон улсын харилцаа зэрэг олон шинжлэх ухааны уулзвар дээр бие даан салбарлан эрчимтэй хөгжиж байна. Тухайлбал: *Лимологи*- улсын хил зааглалын ухаан, *Погранлоги*-хил судлалын ухаан, *Границеведение*-хил шинжлэхүй гэх мэт. Эдгээр үндэслэл нь энэхүү судалгааг явуулах хэрэгцээ шаардлага байгааг гэрчилнэ.

Судалгааны баг, маршрут:

Хээрийн судалгааг 2023 оны 9 сарын 18-наас 10 сарын 6 хүртэл 18 хоногийн хугацаанд томилолтоор гүйцэтгэв. Судалгааны багт ШУА-ийн Газарзүй Геоэкологийн Хүрээлэнгийн НЭЗГСалбарын тэргүүлэх ажилтан, доктор С.Энх-Амгалан (*багийн ахлагч, нийгмийн газарзүйч*), ДХИС-ийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн доктор Ц.Ганболд (*хил судлаач*), ШУА-ийн Философи социологийн хүрээлэнгийн Баян-Өлгий дэх салбарын судлаач, докторант Н.Эрдэнэбаяр (*угсаатан зүй судлаач*), ШУА-ийн Газарзүй Геоэкологийн Хүрээлэнгийн Зурагзүй Зайнаас тандан судлалын салбарын ажилтан докторант М.Нямхүү (*физик газарзүйч*), МУБИС-ийн Газарзүйн тэнхимийн оюутан Ш.Мипан, жолооч С.Батсайхан нарын бүрэлдэхүүнтэй ажиллав. Судалгааны хүрээнд нийт 4500 км орчим замыг Баян-Өлгий аймгийн Алтай, Цэнгэл, Буянт, Ногооннуур, Цагааннуур сумдын нутаг дэвсгэрт гүйцэтгэв (Зураг 1).

Зураг 1. Хээрийн судалгааны маршрут (Баян-Өлгий, 2023.09 сар)



Гүйцэтгэсэн ажил

Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Толбо, Ногоон нуур, Сагсай сумууд нь Монгол орны Баруун захын хилийн бүс нутагт хамрагдана. Судалгааны анхан шатны мэдээ материалыг бодитой болгох үүднээс Баян-Өлгий аймгийн статистикийн газар болон Цэнгэл, Ногоон нуур, Толбо сумдын сүүлийн 10-15 жилийн статистик мэдээлэл болон шаардлагатай тохиолдолд аймаг, сумын архивын мэдээ материалд тулгуурлан ажиллав.

Хээрийн судалгааны хүрээнд сонгон авсан хилийн бүс нутаг дах сум, багийн малчдын бэлчээр ашиглалт, нүүдэл, шилжилт хөдөлгөөн, хүн ам зүйн бүтцийн өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, нөлөөлөл, хохирол болон газар усны нэр, ястан үндэстнүүдийн хэл соёлын өөрчлөлт, өвөрмөц ялгаа болон хилчдийн ахуй хангамж, нийгмийн хамгаалал зэрэг цогц судалгааг гүйцэтгэнэ. Судалгааны хүрээнд

гүйцэтгэх ажлыг багцлан тоймолбол:

1. "Загвар" нутгийн нийгэм эдийн засаг, байгалийн нөхцөл, нөөц, тулгамдаж буй асуудлууд:

❖ Хүн ам, нийгмийн газарзүйн судалгаа (хүн амын бүтэц, шилжилт хөдөлгөөн, боловсрол, эрүүл мэнд)

❖ Судалгааны бүс нутгийн Физик газарзүй, газар ашиглалтын өнөөгийн байдал

❖ Газар, бэлчээрийн төлөв (улирлын бэлчээр ашиглалт, нүүдэл, суурьшил)

❖ Угсаатан зүйн бүтэц, өөрчлөлт, уламжлалт соёл (сум, багийн жишээгээр)

❖ Газар усны нэр, түүний өөрчлөлт (сонгон авсан багийн жишээгээр)

❖ Байгалийн гамшигт үзэгдэл, давтамж нөлөөлөл (ган зуд, үер, их цас, шороон шуурга г.м)

❖ Байгалийн нөөц, баялаг (байгалийн үзэсгэлэнт газар, ховор, нэн ховор амьтан, шувуу, түүх, соёлын дурсгалт газар, рашаан,

Улсын болон орон нутгийн ТХГН,
отор болон хадлангийн бүс нутаг)

❖ Экологийн нөхцөл
(цөлжилт, бэлчээрийн доройтол,
ундны усны чанар г.м)

2. Судалгааны бүс нутаг дах хил
хамгаалалт, аюулгүй байдал,
тулгамдаж буй асуудлууд:

❖ Хүн ам, нийгмийн газарзүйн
судалгаа (хүн амын бүтэц,
шилжилт хөдөлгөөн, боловсрол,
эрүүл мэнд)

❖ Судалгааны бүс нутгийн
Физик газарзүй, газар ашиглалтын
өнөөгийн байдал

❖ Газар, бэлчээрийн төлөв
(улирлын бэлчээр ашиглалт, нүүдэл,
суурьшил)

❖ Угсаатан зүйн бүтэц,
өөрчлөлт, уламжлалт соёл (сум,
багийн жишээгээр)

❖ Газар усны нэр, түүний
өөрчлөлт (сонгон авсан багийн
жишээгээр)

❖ Байгалийн гамшигт үзэгдэл,
давтамж нөлөөлөл (ган зуд, үер, их
цас, шороон шуурга г.м)

❖ Байгалийн нөөц, баялаг
(байгалийн үзэсгэлэнт газар, ховор,
нэн ховор амьтан, шувуу, түүх,
соёлын дурсгалт газар, рашаан,
Улсын болон орон нутгийн ТХГН,
отор болон хадлангийн бүс нутаг)

❖ Экологийн нөхцөл
(цөлжилт, бэлчээрийн доройтол,
ундны усны чанар г.м) зэрэг болно.